

СОЁМБО МЭДЭЭ

"СОЁМБО" РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.03.03 №01 (01)

Мэндийн зурвас

Монгол Улсын анхны Баянмы нэг Батлан хамгаалах яамны 110, Орчин цагийн Зэвсэгт хүчний 100, Монгол хүн сансарт ниссэний 40 жил, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын түүхт ойн босгон дээр БХЯ-ны харьяа "Соёмбо" редакцын хамт олон "Соёмбо-Мэдээ" өдөр тутмын цахим сонины анхны дугаарыг эрхэм уншигч тантай хамт өлгийдөн авч байгаадаа баяртай байна.

Мэдээллийн эрин зуунд бид цаг хугацаатай өрсөн мэдээлэл олж авах, бусдад дамжуулах үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ нийтлэлийн хүртээмжийг сайжруулах, мэдээллийн урсгал, түүний тоо, чанар, давтамж, эргэлтийг нэмэгдүүлж, тэнцвэртэй, бодитой, шуурхай, эрэлт хэрэгцээтэй мэдээ, нийтлэлийг уншигчдад хүргэхийн тулд "Соёмбо-Мэдээ" өдөр тутмын цахим сониныг санаачлан уншигчдадаа хүргэж байна. Өдөр тутмын энэхүү цахим сониндоор дамжуулан Зэвсэгт хүчний нийт уншигчид Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний хэмжээнд өрнөсөн ажил, арга хэмжээг цаг тухайд нь мэдээллийн дахин нэг шинэ сувагар хүлээн авах боломж ийнхүү бүрдлээ.

Цаашид та бүхэн тус цахим сониныг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн вэб сайт болон "Соёмбо" сонины гэж хуудас, БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалуудын дотоод сүлжээ, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарууд албаны цахим хаягаараа дамжуулан тогтмол хүлээн авч унших боломжтой юм.

Өглөө бүхний ургах нартай зэрэгцэн "Соёмбо-Мэдээ" өдөр тутмын цахим сониндоороо учран золгож байхын өлзийтэй өрөөлийг өргөн дэвшүүлэе!

Хурандаа С.ТӨМӨРХУЯГ

ҮЙЛ ЯВДАЛ

ТӨРЛИЙН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ НАР ТОМИЛОГДЛОО



УИХ-ын 2020 оны хаврын ээлжит чуулганаар Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдаж Зэвсэгт хүчний бүтцэд Хуурай замын цэргийн командлал, Агаарын цэргийн командлалаас гадна шинээр Тусгай хүчний цэргийн командлал, Кибер аюулгүй байдлын цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар байгуулагдсан юм. Хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Тусгай хүчний цэргийн командлагчаар хурандаа Б.Баатар, Кибер аюулгүй байдлын цэргийн командлагчаар хурандаа Д.Баасандамба нар томилогдсоныг өчигдөр ЗХЖШ болон төрлийн цэргийн командлалын бүрэлдэхүүнд ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг танилцуулж, баяр хүргэлээ. Хошууч генерал Д.Ганзориг "Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх ажил шат дараатай

явагдаж байна. Үүний нэг нь яах аргагүй шинээр байгуулагдсан төрлийн цэргийн командлал, удирдах газраа байгуулж, томилгоожуулан ажил үүрэгт нь оруулж байгаа явдал юм" гээд шинээр томилогдсон командлагч нарт хандаж "Нэн хариуцлагатай үүрэг та нарын өмнө байна. Та бүгдэд шинэ төрлийн цэргийг эмхлэн зохион байгуулж бэхжүүлэх үйлсэд тань амжилт хүсье. Аливаа ажлыг эхлүүлэх төвөгтэй, бас ээдрээтэй. Манай Зэвсэгт хүчний Төрлийн цэргийн шинэ дарга нар энэ ажлыг огт түүртэлгүй хийж чадна гэдэгт итгэл төгс байна" гэлээ. Үүний дараа тэрээр орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээний явцын талаар мэдээлэл хүргээд бие бүрэлдэхүүнийг "Covid-19" цар тахлаас цаг ямагт урьдчилан сэргийлж, халдвар хамгааллын дэглэмийг сайтар баримтлахыг үүрэг болгосон юм.



ЗЭВСЭГТ ХҮЧИН-100

КОМИССЫН ЭЭЛЖИТ ХУРАЛ БОЛОВ

Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгуулагдсаны 110, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх комиссын ээлжит хуралдаан өчигдөр болов.

Хурлаар Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баяр, "Монгол цэргийн өдөр"-ийг тохиолдуулан зохион байгуулж байгаа ажил, арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэрхэн сурталчлах, ойн хүрээнд Эрдэм шинжилгээний бага хурал болон бусад томоохон арга хэмжээг хэрхэн зохион байгуулах зэрэг асуудлыг хэлэлцлээ. Үүний дараа Батлан хамгаалахын дэд сайд, ажлын хэсгийн ахлагч Б.Баярмагнай холбогдох гишүүдэд үүрэг чиглэл өгсөн юм.



АГААРЫН ЦЭРГИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛЛОО

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний

хүрээлэн, Үндэсний Батлан хамгаалахын их сургууль хамтран "Зэвсэгт хүчний 100

жил-Агаарын цэргийн түүхэн үүрэг, хөгжлийн хандлага" сэдэвт эрдэм шинжилгээний

цахим хурлыг өчигдөр зохион байгууллаа.

Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай хурлыг нээж хэлсэн үгэндээ, "Төрөөс цэргийн шинэчлэлийг эрчимжүүлж, улс орныг батлан хамгаалах бүрдүүлэх, Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх бодлого, стратегийг хэрэгжүүлж буй үед энэхүү эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж байгаа нь сайшаалтай. Нийгмийн аливаа институцын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, ололт амжилт, туршлага, сургамжийг судлан хэлэлцэх, тулгамдсан асуудал, тулгарч болох бэрхшээлийг урьдчилан олж харах нь амжилтын үндэс юм" гэв. Мөн БХЯ-ны ШУТЗ-өөс энэ оны эхний хоёр улиралд багтаан "Батлан хамгаалахын шинжлэх ухаан, технологи, инновацыг 2021-2030 онд хөгжүүлэх бодлого" баримт бичгийг боловсруулан батлуулахаар ажиллаж байгаагаар онцоллоо.

(Үргэлжлэл нь II нүүрт)



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 4°C	☁️ -11°C

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39°C	☁️ 25°C

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 17°C	☁️ 2°C

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,848.0	2,851.0
EUR 🇪🇺	3,430.0	3,445.0
CNY 🇨🇳	440.0	441.5
RUB 🇷🇺	37.80	39.50
JPY 🇯🇵	26.37	26.89
KRW 🇰🇷	2.46	2.59

КОВИД-19 МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	48
НИЙТ БҮРТГЭГДСЭН	3000
ЭДГЭРСЭН	2330
НАС БАРСАН	6

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН	18
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	201
ЭДГЭРСЭН	734

ӨРНИЙН ЗУРХАЙ

2021.03.03. /ЛХАГВА ГАРАГ/

ХАВРЫН ТЭРГҮҮН ЦАГААН БАР САРЫН ЕСӨН УЛААН ЦАГААН НОХОЙ ӨДӨР

Үс засуулвал: Сайн нөхөртэй нөхөрлөнө.

Наран ургах, шингэх: 07.29-18.39

Барилдлага: Үл зохилдох

Шүтэн барилдлага: Төрөхүй

Суудал: Мод

Аргын тооллын 3 дугаар сарын 3, Буд гараг. Билгийн тооллын 19, Салхины эх одтой, цагаан нохой өдөр. Өдрийн наран 7 цаг 29 минутад мандан, 18 цаг 39 минутад жаргана. Тухайн өдөр бар жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, хүүхэд үрчлэн авах, гэр, байшингийн суурь тавихад сайн. Эрдэнийг гадагш өгөх, нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийхэд муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал "Сайн нөхөртэй учрах" хэмээх сайн.

АГААРЫН ЦЭРГИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛЛОО

(Түрүүч нь I нүүрт)

Дээрх бодлогын баримт бичиг батлагдсанаар батлан хамгаалах салбарын эрдэмтэн, судлаачдын цэргийн шинжлэх ухааны хөгжүүлэх, шинэ технологи, инновацыг салбартаа нэвтрүүлэх, бодлого, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа улам тодорхой болох аж.

Энэ үеэр ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг "Монгол Улсын Агаарын цэрэг туулсан түүхэн замналынхаа хугацаанд нэлээд амжилт, бүтээлийг гаргасан. Агаарын цэргийн түүхийг Монгол Улсын иргэний нисэхийн түүхтэй холбож үзэх нь зүйтэй. Тийм болохоор ИНЕГ-тай үйл ажиллагаагаа

уялдуулан ажиллана гэдэгт итгэлтэй байна. Байлдааны түүхэн уламжлалын хувьд Халхын голын байлдаан, Баруун хилийн тулгаралтаас үүдэлтэй бөгөөд богинохон хугацаанд Агаарын цэргийн соёл, уламжлалыг бий болгож чадсан юм. Орчин цагт тавигдаж байгаа, ялангуяа байлдааны үйл ажиллагааны шаардлагыг Агаарын цэргийн бие бүрэлдэхүүн бүрэн ухамсарлаж байгаад сэтгэл дүүрэн байна. Өнгөрсөн хугацаанд Агаарын цэргийн бие бүрэлдэхүүн зэвсэг, техникээ сайжруулах тал дээр олон ажил өрнүүлж, нэлээд ахиц дэвшилд хүрсэн. Цаашид Агаарын цэргийн салбарыг нэмэгдүүлэх, зэвсэг, техникийг шинэчлэх, техник технологийн

судалгааны ажлуудыг эрчимтэй явуулах, Монгол Улсын агаарын хил, орон зайн халдашгүй дархан байдлыг хангахад үүргээ амжилттай гүйцэтгэнэ гэдэгт итгэл дүүрэн байна" гээд Зэвсэгт хүчний 100 жилийн ойн мэндчилгээ дэвшүүлэв.

Хурлаар Зэвсэгт хүчний 100 жилийн түүхэнд Агаарын цэргийн гүйцэтгэсэн үүрэг, сургамж, орчин цагт тавигдаж буй шаардлага, цаашдын хөгжлийн чиг хандлагын талаарх эрдэмтэн судлаачдын шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, дүгнэлтийг хэлэлцэж, тэтгэвэр чөлөөнд гарсан ахмадуудын үйлс, гавьяаг залуу хойч үедээ ойлгуулах, сурталчлан таниулах зорилгоор зохион байгуулснаараа ач

холбогдолтой юм.

Агаарын цэргийн командлагч, бригадын генерал О.Энхбаяр "Зэвсэгт хүчний Агаарын цэргийг ашиглах, үзэл баримтлал, хөгжлийн стратеги, зорилт", Батлан хамгаалахын сайдын зөвлөх, доктор, бэлтгэл хурандаа Б.Эрдэнэбат "Нисгэгчгүй нисэх систем ба Агаарын довтолгооны цэрэг", бэлтгэл хурандаа Ч.Болдбаатар "Агаарын зайн хяналт, удирдлагын нэгдсэн сүлжээ байгуулах эрх зүйн таатай орчин, шийдлийн гаргалгаа" зэрэг сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн нь Агаарын цэргийн цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход ихээхэн түлхэц болсноороо онцлог байв.

"Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 100 жилийн ойд зориулсан тус хуралд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг, Батлан хамгаалахын сайдын зөвлөх, доктор, бэлтгэл хурандаа Б.Эрдэнэбат, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, хурандаа Ц.Жавхланбаатар, БХЯ-ны СБТГ-ын дарга, хурандаа С.Ганбямба, ЗХЖШ-ын АУГ-ын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, БХЯ-ны ШУТЗ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, хурандаа Д.Содномцог, БХЭШХ-ийн эрдэмтэн, судлаачид болон Агаарын цэргийн үе үеийн командлагч, ахмад дайчдын төлөөлөл оролцлоо.

ХИЛИЙН ЧАНАДААС

ХОЛЫН ЭРГҮҮЛИЙН ХАМГИЙН ШИЛДЭГ БҮЛЭГ...

НҮБ-аас БНӨСУ-д явуулж байгаа "UNMISS" энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын

Маёом суурины удирдлага, хүчний байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, "UNMISS" ажиллагаа,

сэтгэгдлээ илэрхийлсэн юм.

Дашрамд дурдахад Маёом суурин нь 120 гаруй мянган хүн амтай бөгөөд дийлэнхийг нь Нуэр омгийнхон эзэлдэг. "Юнити" секторын томоохон сууринуудын нэг аж. Мотобудлагын батальоны томилгоот бүрэлдэхүүн хариуцлагын бүсэд эргүүл хийх үеэр НҮБ-ын болон Монгол цэргийн сүр хүчийг үзүүлэн, цагийн байдлыг судлан тогтоох, мэдээлэл олзворлох, иргэн-цэргийн харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, тосгон сууринуудын аюулгүй байдлыг хангах зорилготойгоор холын эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа юм. Тус эргүүлийн бүлэг нь үүрэг гүйцэтгэж эхэлснээс хойш 3000 гаруй км зам маршрутын дагуу эргүүлийн үүрэг гүйцэтгэж, 20 гаруй суурин, тосгоны иргэдтэй уулзалт хийгээд байна.

Түүнчлэн тус улсын Жуба, Вау, Бентью хотыг холбосон төв хангалтын зам дагуу оршдог тул худалдаа, арилжаа хөгжиж байсан боловч сүүлийн жилүүдэд замын ихэнх хэсэгт хар шавар, хатуулаг хөрс тогтож, замын нөхцөл муудсанаас шалтгаалан худалдаа, наймаа эрс багасаж, хүнсний хомсдоллоо үүдэлтэй хулгай, дээрэм, насанд хүрээгүйчүүдийн зэвсэгт бүлэг этгээдүүдийн гэмт хэргийн гаралт ихэссэн, цагийн байдлын тогтворгүй бүс нутаг юм.



Зэвсэгт хүчний Х ээлжийн батальоны холын эргүүлийн бүлгийн үүрэг гүйцэтгэлт, нөхцөл байдалтай танилцахаар Хүчний командлагч, дэслэгч генерал Шайлеш Тинайкар, "Юнити" секторын командлагч, бригадын генерал Шамин Камал тэргүүтэй Хүчний болон Секторын командлалын албаны хүмүүс Маёом сууринд ажлын айлчлал хийв.

Энэ үеэр манай цэргийн багийн удирдлага болон

холын эргүүлийн бүлгийн үйл ажиллагааны талаар харилцан санал солилцлоо. Дэслэгч генерал Тинайкар Маёом сууринд ажиллах үеэрээ, "Энхийг сахиулах ажиллагааны газар оронд монгол цэргүүд ямагт шилдэг нь байдаг гэж бид үнэлдэг. Тиймээс ч та бүхнээр бахархдаг. Бидний итгэл найдварыг танай холын эргүүлийн бүлэг бататгаж байгаа. Та бүхэн миний харж байсан хамгийн шилдэг холын эргүүлийн бүлэг байлаа" хэмээн

"ДАНКОН"-Д МОНГОЛ ЦЭРГҮҮД МАНЛАЙЛАВ



"Мармал" баазын удирдлагаас зохион байгуулсан 25 км-ийн зайн "DANCON" маршид Монгол Улсын XIII ээлжийн цэргийн багийн 38 цэргийн алба хаагч амжилттай оролцон түрүүлээ. "DANCON" гэдэг нь "Danish Contingent"

гэсэн үгийн товчлол бөгөөд 1972 онд Кипрт үүрэг гүйцэтгэж байсан Данийн цэргийн баг хамтран алба хааж байсан холбоотны цэргүүдийн дунд 25, 40 км-ийн явган маршийг зохион байгуулсан цагаас өнөөг хүртэл жил бүр уламжлал болон явагдаж байгаа юм.

ЦАХИМ ШУУДАНД

ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ ДАЙЧИД ХӨЛ ХОРИОНЫ ӨДРҮҮДЭД ...



Хатуу хөл хорионы дэглэмийн өдрүүдэд Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Налайх, Багануур, Багахангай дүүргийн Цэргийн штабын офицер, ахлагч, бэлтгэл офицерууд болон цэргийн дүйцүүлэх албаны 170 гаруй алба хаагч нутаг дэвсгэрийнхээ цагдаагийн албан хаагчидтай хамтран хоёр ээлжээр хэв журам сахиулах, явган эргүүл, "Нэг хаалга-Нэг шинжилгээ" аяны хүрээнд шинжилгээ өгөх иргэдийн ирцийг нэмэгдүүлэх ажилд оролцлоо.

Мөн бие даан эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа төрийн алба хаагчдад халуун хоол цай, аарц хүргэх, тусгаарлагдсан иргэдэд хоол зөөвөрлөх үүргүүдийг тус тус гүйцэтгэжээ.

ИРГЭДЭД ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭВ



Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн хамт олон нийгмийн хариуцлагын хүрээнд тус дүүргийн 28 дугаар хорооны таван өрхийг сонгож, тус бүр 100 мянган төгрөгийн өртөг бүхий найман нэр төрлийн эд материалын тусламж үзүүллээ.

Тус анги нь нийслэлийн БЗД-ийн 28 дугаар хорооны амьдралын түвшин доогуур эмзэг бүлгийн айл өрхүүдэд эд материалын тусламж үзүүлж, амьдрал ахуйд нь дэмжлэг болох ажлыг уламжлал болгон зохион байгуулдаг билээ. Энэхүү арга хэмжээ нь Ковид-19 цар тахлын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдлын болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед зохион байгуулагдсанаараа онцлог юм.

ДЭМ ДЭМЭНДЭЭ



Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн хамт олон амьгисаа тэтгэвэр, чөлөөнд гарсан ахмадуудын өрхийн амьжиргааны түвшний судалгааг гаргаж, бэлтгэл хошууч Г.Ролон, иргэн С.Батбаяр нарт тус бүр 20 шуудай сайжруулсан түлш, бэлэг дурсгалын зүйл гардуулав.

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор
Хурандаа
САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ

Эхийг "Соёмбо" сонини редакцал бэлтгэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сонини нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонини мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029